


УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг дахь Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/81/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn  
Аудитор: Р.Аюуш  
Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв.....	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. Аудитын тайлан .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч
НА	Нийцлийн аудит



УВС АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
Ц.МӨНХБАЯР ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17.  
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.07 № УВА-2023/81/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулган орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг орон тоо, төсөв, ашиглаж буй компьютер техник, хэрэгслийн хамт одоо эрхэлж байгаа чиг үүрэг, мэргэжлийн чиглэлийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д заасан байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 417 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/103, А/104 дүгээр захирамжийн дагуу Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгө, бараа материалыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэр гараагүй тул, орон нутгийн чиглэлийн байгууллагуудад картаар хүлээлгэн өгч, 2022 оны санхүүгийн тайланд балансад бүртгэлтэйгээр тайлагнасан байна.

0200006040

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг үрж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>117,617,983.01</b>	<b>25,618,802.44</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>54,988.00</b>	00.00
<b>335</b>	Бусад авлага	54,988.00	00.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>1,080,000.00</b>	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,080,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>116,482,995.01</b>	<b>25,618,802.44</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	8,342,840.90	2,845,980.00
35110	Тусгай зориулалттай материал	8,342,840.90	2,845,980.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	108,140,154.11	22,772,822.44
35410	Бичиг хэргийн материал	6,386,839.00	00.00
35420	Аж ахуйн материал	4,247,888.00	1,540,387.50
35430	Сэлбэг хэрэгсэл	2,644,400.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	94,861,027.11	21,232,434.94
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>895,773,317.07</b>	<b>790,565,471.57</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	895,773,317.07	790,565,471.57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	869,518,866.82	764,436,022.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	768,983,101.00	767,432,001.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-79,572,770.44	-102,115,110.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	53,280,000.00	53,280,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,065,591.65	-40,152,464.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	733,437,967.84	343,560,279.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	-616,159,014.20	-284,661,038.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,806,634.28	63,941,676.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	-66,984,615.14	-49,557,549.13
39209	Зам, гүүрийн байгууламж	6,000,000.00	6,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-5,174,810.54	-5,636,057.39
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,122,626.00	17,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-15,154,660.33	-4,655,714.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	26,254,450.25	26,129,448.70
39301	Програм хангамж	1,213,000.00	1,213,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-858,549.75	-983,551.30
39303	Бусад биет бус хөрөнгө	25,900,000.00	25,900,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,013,391,300.08</b>	<b>816,184,271.01</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,013,391,300.08</b>	<b>816,184,274.01</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	736,275,128.58	736,275,128.58
51101	Өмч: - төрийн	736,275,128.58	736,275,128.58
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-53,405,580.70	-250,612,606.77
51210	Өмнөх үеийн үр дүн	3,352,354.03	-53,405,580.70
51220	Тайлант үеийн үр дүн	-56,757,934.73	-197,207,026.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	330,521,752.20	330,521,752.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,013,391,300.08</b>	<b>816,184,274.01</b>

ЗОРНИЛГОЙ  
САНАА ДҮГНЭЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,165,422,449.50</b>	<b>928,388,171.64</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>33,114,829.50</b>	<b>44,132,071.64</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	33,114,829.50	44,132,071.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,114,829.50	44,132,071.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,992,500.00	19,082,088.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,122,329.50	25,049,983.64
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,132,307,620.00</b>	<b>884,256,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,132,307,620.00	884,256,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,116,255,200.00	883,956,100.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	11,683,000.00	300,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,369,420.00	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,491,420.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	878,000.00	0.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,222,180,384.23</b>	<b>1,081,304,074.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,222,180,384.23</b>	<b>1,081,304,074.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,107,299,415.81	1,056,229,135.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	697,726,383.54	624,200,697.36
210101	Үндсэн цалин	513,377,585.86	412,337,340.30
210102	Нэмэгдэл	161,114,049.26	149,210,791.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,349,406.63	33,509,299.43
210104	Урамшуулал	1,885,341.79	29,143,266.43
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	91,606,433.04	75,026,533.01
210201	Тэтгэврийн даатгал	63,721,519.81	50,636,004.09
210202	Тэтгэмжийн даатгал	7,113,213.50	6,508,788.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,603,450.92	4,212,799.38
210204	Ажилгүйдлийн даатгал	1,378,658.57	2,033,199.21
210205	Эрүүл мэндийн даатгал	13,789,590.24	11,635,741.34
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	66,551,278.00	60,438,599.00
210301	Гэрэл, цахилгаан	5,310,525.00	4,949,100.00
210302	Түлш, халаалт	55,426,333.00	50,893,920.00
210303	Цэвэр, бохир ус	3,698,420.00	2,030,579.00
210304	Байрны түрээс	2,116,000.00	2,565,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,126,553.09	73,949,775.39
210401	Бичиг хэрэг	4,063,642.59	11,900,276.24
210402	Тээвэр, шатахуун	30,994,905.00	28,376,588.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,068,005.50	8,774,257.00

20

САЛГАЛ ДҮГНЭЛТ

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	232,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,802,228.50	24,666,154.15
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,235,170.00</b>	<b>34,290,657.74</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,018,320.00	30,384,320.00
210502	Хоол, хүнс	2,216,850.00	3,373,337.74
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	533,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>43,062,550.00</b>	<b>64,047,492.18</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,000.00	6,250,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,499,450.00	45,530,878.85
210604	Урсгал засвар	6,413,100.00	12,266,613.33
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,025,500.00</b>	<b>25,750,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,025,500.00	25,750,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,834,251.00</b>	<b>9,796,775.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,971,550.00	4,198,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	786,200.00	785,544.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,501.00	315,601.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,500.00	98,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	226,500.00	3,126,000.00
210807	Газрын төлбөр	259,000.00	259,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,908,000.00	582,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>97,131,297.14</b>	<b>88,728,105.61</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,493,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,612,300.00	2,392,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,518,997.14	82,842,005.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>114,880,968.42</b>	<b>25,074,938.89</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>15,992,500.00</b>	<b>15,900,000.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,992,500.00	15,900,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,605,700.00</b>	<b>2,634,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,764,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,841,000.00	2,634,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>37,282,768.42</b>	<b>6,540,438.89</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,282,768.42	6,540,438.89
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-56,757,934.73</u></b>	<b><u>-152,915,902.51</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>44,291,123.53</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	44,291,123.53
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>0.00</b>	<b>-44,291,123.53</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-56,757,934.73</u></b>	<b><u>-197,207,026.07</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,148,300,120.00</b>	<b>903,338,188.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,992,500.00	19,082,088.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,992,500.00	19,082,088.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,132,307,620.00</b>	<b>884,256,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,127,938,20.00</b>	<b>884,256,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,116,255,200.00	883,956,100.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	11,683,000.00	300,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,369,420.00</b>	<b>0.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,491,420.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	878,000.00	0.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,133,570,620.00</b>	<b>899,138,188.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,133,570,620.00</b>	<b>899,138,188.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,018,710,651.58</b>	<b>874,063,249.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>697,726,383.54</b>	<b>624,145,709.36</b>
210101	Үндсэн цалин	513,377,585.86	412,282,352.30
210102	Нэмэгдэл	161,114,049.26	149,210,791.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,349,406.63	33,509,299.43
210104	Урамшуулал	1,885,341.79	29,143,266.43
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>91,661,421.04</b>	<b>75,882,690.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	63,776,507.81	50,636,004.09
210202	Тэтгэмжийн даатгал	7,113,213.50	6,508,788.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,603,450.92	4,996,799.38
210204	Ажилгүйдлийн даатгал	1,378,658.57	1,249,199.21
210205	Эрүүл мэндийн даатгал	13,789,590.24	12,491,899.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>67,631,278.00</b>	<b>59,358,599.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,310,525.00	4,949,100.00
210302	Түлш, халаалт	55,426,333.00	50,893,920.00
210303	Цэвэр, бохир ус	3,698,420.00	2,030,579.00
210304	Байрны түрээс	3,196,000.00	1,485,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>60,337,348.00</b>	<b>45,863,845.00</b>
210401	Бичиг хэрэг	5,991,000.00	5,365,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,994,905.00	28,376,588.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,578,843.00	8,774,257.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	232,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,522,600.00	3,115,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,162,370.00</b>	<b>14,183,480.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,945,520.00	11,133,300.00
210502	Хоол, хүнс	2,216,850.00	2,517,180.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	533,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>45,787,800.00</b>	<b>14,563,550.00</b>

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,650,000.00	4,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	31,054,700.00	2,673,550.00
210604	Урсгал засвар	12,083,100.00	11,890,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,025,500.00</b>	<b>25,750,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,025,500.00	25,750,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,766,251.00</b>	<b>8,428,775.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,469,550.00	4,198,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	786,200.00	785,544.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,501.00	315,601.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,500.00	98,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,594,500.00	1,758,000.00
210807	Газрын төлбөр	259,000.00	259,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,974,000.00	582,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,612,300.00</b>	<b>5,886,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,493,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,612,300.00	2,392,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>114,859,968.42</b>	<b>25,074,938.89</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>15,992,500.00</b>	<b>19,082,088.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,992,500.00	19,082,088.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,584,700.00</b>	<b>2,634,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,764,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,820,000.00	2,634,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>37,282,768.42</b>	<b>3,358,350.89</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,282,768.42	3,358,350.89
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>14,729,500.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>14,729,500.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөг/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	736,275,128.58	330,521,752.20	3,352,354.03		1,070,149,234.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>736,275,128.58</b>	<b>330,521,752.20</b>	<b>3,352,354.03</b>		<b>1,070,149,234.81</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн			-56,757,934.73		-56,757,934.73
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	736,275,128.58	330,521,752.20	-53,405,580.70		1,013,391,300.08
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл					
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	736,275,128.58	330,521,752.20	-53,405,580.70		1,013,391,300.08
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>					
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00		-197,207,026.07		-197,207,026.07
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	736,275,128.58	330,521,752.20	-250,612,606.77		816,184,274.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>883,956,100.00</b>	<b>880,597,749.11</b>	3,358,350.89
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>883,956,100.00</b>	<b>880,597,749.11</b>	3,358,350.89
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>881,288,100.00</b>	<b>877,963,249.11</b>	3,324,850.89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>624,601,500.00</b>	<b>624,145,709.36</b>	<b>455,790.64</b>
210101	Үндсэн цалин	400,168,700.00	412,282,352.30	-12,113,652.30
210102	Нэмэгдэл	149,210,800.00	149,210,791.20	8.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,122,000.00	33,509,299.43	612,700.57
210104	Урамшуулал	41,100,000.00	29,143,266.43	11,956,733.57
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,075,100.00</b>	<b>75,882,690.75</b>	2,192,409.25
210201	Тэтгэврийн даатгал	53091,100.00	50,636,004.09	2,455,095.91
210202	Тэтгэмжийн даатгал	6,246,000.00	6,508,788.99	-262,788.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,996,800.00	4,996,799.38	0.62
210204	Ажилгүйдлийн даатгал	1,249,200.00	1,249,199.21	0.79
210205	Эрүүл мэндийн даатгал	12,492,000.00	12,491,899.08	100.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>59,358,600.00</b>	<b>59,358,599.00</b>	1.00
210301	Гэрэл, цахилгаан	5,050,900.00	4,949,100.00	101,800.00
210302	Түлш, халаалт	49,636,100.00	50,893,920.00	-1,257,820.00
210303	Цэвэр, бохир ус	3,172,300.00	2,030,579.00	1,141,721.00
210304	Байрны түрээс	1,499,300.00	1,485,000.00	14,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>45,593,900.00</b>	<b>45,563,845.00</b>	30,055.00
210401	Бичиг хэрэг	5,516,900.00	5,365,000.00	151,900.00
210402	Тээвэр, шатахуун	28,380,300.00	28,376,588.00	3,712.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,786,200.00	8,774,257.00	11,943.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	232,500.00	232,500.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,678,000.00	2,815,500.00	-137,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>14,425,600.00</b>	<b>14,183,480.00</b>	242,120.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,133,300.00	11,133,300.00	0.00
210502	Хоол, хүнс	2,759,300.00	2,517,180.00	242,120.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	533,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,765,700.00</b>	<b>18,763,550.00</b>	2,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,202,100.00	4,200,000.00	2,100.00
210602	Тавилга			
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,673,600.00	2,673,550.00	50.00
210604	Урсгал засвар	11,890,000.00	11,890,000.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>25,924,300.00</b>	<b>25,750,500.00</b>	173,800.00
210702	Дотоод албан томилолт	25,924,300.00	25,750,500.00	173,800.00

СЭМГЭЙН ДЭГЭЭСЭН

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8644,000.00</b>	<b>8,428,775.00</b>	<b>215,225.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,406,800.00	4,198,630.00	208,170.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	786,200.00	785,544.00	656.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,700.00	315,601.00	99.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	104,000.00	98,000.00	6,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,758,000.00	1,758,000.00	0.00
210807	Газрын төлбөр	259,000.00	259,000.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	582,300.00	582,000.00	300.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,899,400.00</b>	<b>5,886,100.00</b>	<b>13,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,493,600.00	6,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,399,400.00	2,392,500.00	6,900.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,668,000.00</b>	<b>21,716,588.00</b>	<b>19,048,588.00</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>19,082,088.00</b>	<b>19,082,088.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	19,082,088.00	19,082,088.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,668,000.00</b>	<b>2,634,500.00</b>	<b>33,500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,668,000.00	2,634,500.00	33,500.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>883,956,100.00</b>	<b>880,597,749.00</b>	<b>3,358,350.89</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	883,956,100.00	880,597,749.00	3,358,350.89
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	
610001	Төсвийн байгууллага	1	1	
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>47</b>	<b>47</b>	
620001	Удирдах ажилтан	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	27	27	
620003	Үйлчлэх ажилтан	19	19	

### Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөг/	
			Гүйцэтгэл	Зөрүү
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>300,000.00</b>	<b>-300,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>300,000.00</b>	<b>-300,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		300,000.00	-300,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		300,000.00	-300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		300,000.00	-300,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		<b>300,000.00</b>	<b>-300,000.00</b>

20

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЗАНГААГАХ  
САГАА ДҮГНЭЛТ

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хуулийг сахин мөрдөхөд төрийн өмнөөс мэргэжлийн хяналт тавих, стандартын хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын тогтолцоог сайжруулан, эрсдэлийг бууруулах, хууль тогтоомжийг сурталчлах, хууль тогтоомжийг сахиулан, хүний болон нийгмийн тогтвортой хөгжлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгал болон Татварын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаал
- ✓ Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгах шийдвэрт тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 222,825.8 мянган төгрөгөөр буюу 22 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*


Үзүүлэлт Б	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	1,135.0	0.00	-1,135.0
Бараа материал	116,483.0	25,618.8	-90,864.2
Үндсэн хөрөнгө	895,773.3	790,565.5	-105,207.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,013,391.3</b>	<b>816,184.3</b>	<b>197,207.0</b>
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	736,275.1	736,275.1	0.00
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,013,391.3</b>	<b>816,184.3</b>	<b>197,207.0</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 25,618.8 үлдэгдэлтэй болж 90,864.2 мянган төгрөгөөр буурч нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь Мэргэжлийн хяналтын газрын экспорт, импорт хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс Увс аймаг дахь Гаалийн газарт шилжсэн, мөн Мэргэжлийн хяналтын газар татан бууж байгаатай холбоотой болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 790,565.5 мянган төгрөг болж 105,207.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь 457,341.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлсэн, 21,925.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,789,089.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 3,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,957,550.8 мянган төгрөгөөр бууруулж 831,538.2 мянган төгрөгөөр баталсан байна. 2022 оны төсвийн төслийг 1,957,550.8 мянган төгрөгөөр бууруулан баталсан нь 1,386,116.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг хасаж, Мэргэжлийн хяналтын газрын экспорт, импорт хилийн хорио цээрийн хяналтын хэлтсийн ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бусад холбогдон гарах 571,434.5 мянган төгрөгийн зардлыг нэмэгдүүлэн тусгасантай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор 52,387.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 883,926.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 883,956.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 877,963.2 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 455.8 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Гүйцэтгэлээр 19,082.1 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого бүрдүүлж, 19,082.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70417-Мэргэжлийн хяналт, 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	878,881.3	875,763.3	3,118.0	99.6%
2	70417-Мэргэжлийн хяналт, 80205-Мэдээлэл сурталчилгааны зардал	1,206.8	1,200.0	6.8	99.4%
3	70417-Мэргэжлийн хяналт, 80227-Лабораторийн итгэмжлэл	1,200.0	1,000.0	200.0	83.3%
4	70417-Мэргэжлийн хяналт, 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,668.0	2,634.5	33.5	98.7%

Тайланд онд үндсэн үйл ажиллагааны зориулалтын цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 2,648.2 мянган төгрөг, дотоод албан томилолт болон бараа үйлчилгээний бусад зардлаас 469.8 мянган төгрөг, бусад зориулалт арга хэмжээний зардлаас 240.3 мянган төгрөг, нийт 3,358.3 мянган төгрөгийг хэмнэж улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Биеийн тамир спортын газраас зарлагдсан 20 "Эртэч Монгол-Эрүүл хүн" САНАЛ ДҮҮНЭЭТ

УВС АЙМАГ ДАХЬ ТӨР  
2020  
30  
"Эртэч Монгол-Эрүүл хүн"  
САНАЛ ДҮҮНЭЭТ

уралдааны шагналын 300.0 мянган төгрөгийн орлогыг “Байгууллагын аварга” шалгаруулах спортын арга хэмжээнд зарцуулсан байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70417-Мэргэжлийн хяналт	2022 он	100%	100%	300.0	300.0

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 303 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,222,180.4 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 6,110.9 мянган төгрөгөөр тогтоосныг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,106,922.9 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 5,534.6 мянган төгрөгийн 80 хувиар буюу 4,427.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

20

УВС АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР  
303  
САНАЛ ДҮГИЙН

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



2022 оны 02 сарын 07-ны өдөр

20

УВС АЙМАГ ДА

ЗӨРЧЛӨЛ  
САНАЛ ДҮГНЭЛТ